

# Инфляцийн хүлээлтийн түүвэр судалгаа



2013 ОНЫ 1 САР

МӨНГӨНИЙ БОДЛОГО, СУДАЛГААНЫ ГАЗАР  
СУДАЛГААНЫ ХЭЛТЭС


## ТОВЧ ХУРААНГУЙ

## ИНФЛЯЦИЙН ХҮЛЭЭЛТ

Инфляцийн хүлээлтийн түүвэр судалгааг 2013 оны 1-р сард Улаанбаатар хотын 1000 иргэд, 400 аж ахуй нэгж болон 12 шинжээчдийг хамруулан явууллаа.

Иргэд инфляцийг 2013 оны I улирлын эцэст **15.8%**, IV улирлын эцэст дунджаар **14.4<sup>1</sup>%** хүрнэ гэсэн хүлээлттэй байна. Иргэдийн инфляцийн хүлээлтийн чиглэлийн индекс оны сүүлээр өсөх хандлагатай гарсан хэдий ч “инфляци одоогийнхтой адил түвшинд байна” гэсэн мужид байна. Харин ААН-үүд I улирлын эцэст **11.5%**, IV улирлын эцэст **9.3%**-тай байна гэсэн хүлээлттэй байгаа бол шинжээчдийн хувьд I улирлын эцэст **14.0%**, IV улирлын эцэст инфляци **11.8%**-д хүрнэ гэж таамаглаж байна.

Зураг 1: Иргэд, ААН-ийн инфляцийн хүлээлт болон судлаачдын таамаглал



Сүүдэрлэсэн хэсэг иргэд, ААН-ийн хүлээгдэж буй инфляцийн түвшин болон судлаачдын таамаглалыг илтгэнэ.

Зураг 2: Иргэдийн инфляцийн хүлээлтийн чиглэлийн индекс



2013 оны эхэнд мах, бензин болон бусад гол нэрийн бараа, бүтээгдэхүүний үнэ өссөн нь иргэдийн инфляцийн хүлээлтэнд нөлөөлж ААН болон шинжээчдийн таамаглалаас өндөр гарахад хүргэсэн байна.

Иргэдийн инфляцийн хүлээлтийн чиглэлийн индекс II, IV улирлын эцэст өсдөг I, III улиралд буурдаг хандлага ажиглагдаж байна. II улирлын эцэст улсын баяр наадам, IV улирлын эцэст шинэ жилийн баяр үргэлжлээд цагаан сарын баяр болдогтой холбоотойгоор гол нэрийн бараа, бүтээгдэхүүний үнэ нэмэгддэг нь иргэдийн инфляцийн хүлээлт өсөхөд нөлөөлдөг байна.

ААН болон шинжээчдийн инфляцийн таамаглал өнгөрсөн оноос буурах хандлагатай байгаа нь бодлого баригчдын зүгээс авч хэрэгжүүлж буй өргөн хэрэглээний гол бараа, бүтээгдэхүүний үнийг тогтворжуулах дэд хөтөлбөрүүдийн үйл ажиллагаатай холбоотой.

Иргэдийн инфляцийн хүлээлтийн чиглэлийн индекс өсөх хандлагатай гарсан хэдий ч ААН, шинжээчдийн таамаглалаар 2013 онд инфляци өмнөх оноос буурах хүлээлттэй байна.

## ВАЛЮТЫН ХАНШ


Шинжээчид төгрөгийн ам.доллартай харьцах нэрлэсэн ханш оны эхнээс бага зэрэг чангарч цаашид тогтвортой байхаар таамаглаж байна. Өнгөрсөн оны эцэст урсгал тэнцэл их хэмжээний алдагдалтай гарсан хэдий ч санхүүгийн хөрөнгө оруулалтын хэмжээ эрс нэмэгдэж, төлбөрийн тэнцлийг ашигтай гаргасан нь ханшийг тогтвортой байлгах үндсэн шалтгаан болж байна.

Иргэдийн төгрөгийн ханшийн хүлээлтийн чиглэлийн индексийг харвал 2013 оны эцэст ханш сулрана гэсэн хүлээлт бага зэрэг өсчээ. Харин ААН-үүдийн дийлэнх хувь нь ханш тогтвортой байна гэсэн хүлээлттэй байна.

<sup>1</sup> Иргэдийн инфляцийн хүлээлтийн тоон болон чанарын хариултын дундаж утга

Энэ удаагийн судалгааны дүнгээр 2013 оны эцэст иргэд ханш бага зэрэг сулрана гэсэн хүлээлттэй байгаа хэдий ч ААН, судлаачдын таамаглалаас харахад ханш оны туршид тогтвортой байх хандлагатай байна.

Зураг 3: Төгрөг/Ам доллар



Сүүдэрлэсэн талбай шинжээчдийн таамгийг харуулах бөгөөд хамгийн их, бага болон дундаж утгуудыг зураасаар дүрслэв.


Зураг 4: Төгрөгийн ханш болон төгрөгийн ханшийн чиглэлийн индекс (иргэдийнх)



## ОРЛОГО


Шинжээчдийн хувьд 2013 онд бодит ДНБ өсч жилийн эцэст 15%-ийн өсөлттэй байхаар таамагласан. Эдийн засгийн өндөр өсөлттэй уялдан цалингийн түвшин өсөх хандлага ажиглагдаж, ААН-үүд нэрлэсэн цалингаа дунджаар 14.2%-иар нэмэгдүүлэх төлөвтэй байгаа нь харагдаж байна.

Зураг 5: ААН-ийн дундаж цалин болон ДНБ-ний өсөлт



Сүүдэрлэсэн талбайд шинжээчдийн ДНБ-ний өсөлтийн таамаглал болон ААН-цалингийн өсөлтийн таамаглалыг дүрслэв.

Зураг 6: Өрхийн санхүүгийн байдлын талаарх чиглэлийн индекс (иргэдийнх)



ААН-үүд үйл ажиллагаагаа өргөжүүлэхийн зэрэгцээ шинээр ажлын байр бий болгож, ажилчдынхаа цалингаа нэмэгдүүлэх нь иргэдийн өрхийн санхүүгийн байдал сайжирна гэсэн хүлээлттэй нийцэж байна.

Эдийн засгийн өндөр өсөлт нь ААН-үүдийн орлогыг нэмэгдүүлэн шинээр ажлын байрыг бий болгож, цалинг өсгөхөөр байгаа бөгөөд ирэх онд өрхийн санхүүгийн байдал сайжрах төлөвтэй байна.

## ДҮГНЭЛТ

Энэ оны эхээр бензин, махны үнэ болон цагаан сарын баяраас шалтгаалж гол нэрийн бараа, бүтээгдэхүүний үнэ өссөн нь иргэдийн инфляцийн хүлээлтийг нэмэгдүүлсэн хэдий ч ААН, шинжээчдийн таамаглалаар 2013 онд инфляци аажмаар буурч оны эцэст дунджаар 10 гаруй хувьтай байхаар хүлээгдэж байна. Түүний зэрэгцээ ханш тогтвортой, эдийн засгийн өсөлт өндөр, цалингийн түвшин нэмэгдэж, өрхийн санхүүгийн байдал сайжрах хандлагатай байна.


## 1 ИРГЭДИЙН ИНФЛЯЦИЙН ХҮЛЭЭЛТИЙН ТҮҮВЭР СУДАЛГААНЫ ҮР ДҮН

Түүвэр судалгаанд Улаанбаатар хотын 9 дүүргийн 135 хорооноос 1000 иргэдийг санамсаргүй түүврийн аргачлалаар сонгож хамрууллаа. Тоон болон чанарын хариултын дунджаар иргэд инфляцийн хүлээлтийг 2013 оны I улирлын эцэст **15.8%**, II улирлын эцэст **14.4%**, III улирлын эцэст **14.4%**, IV улирлын эцэст **14.4%** болно гэсэн хүлээлттэй байна.

### СУДАЛГААНД ОРОЛЦОГЧДЫН ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ


- Судалгаанд оролцогчдын 52.7% нь эмэгтэй;
- Насны бүтцийг харвал 54.1% нь 25-44 насныхан;
- Боловсролын түвшингээр авч үзвэл 83.8% нь бүрэн дунд болон дээд боловсролтой;
- Ам бүлийн тоог харвал 83.3% нь 2-5 ам бүлтэй;
- Өрхийн орлогын зүгээс харвал 62.0% нь 200-600 мянган төгрөгийн орлоготой, 7.3% нь 200 мянгаас бага, 30.7% нь 600 мянган төгрөгөөс дээш орлоготой өрхүүд байлаа.
- Ажил эрхлэлтийн байдлыг авч үзвэл 45.4% нь хувийн салбарт ажилладаг, 14.6% нь төрийн албанд, 28.3% нь ажилгүй;

Зураг 1.1: Жилийн инфляцийн хүлээлтийн чиглэлийн индекс



**Санамж:** Чиглэлийн индекс нь [-1; 3] хооронд утга авах бөгөөд [-1;0] үнэ буурна, [0] үнэ өөрчлөгдөхгүй, [0;1] инфляци одоогийнхоос буурна, [1;2] инфляци одоогийнхтой адил түвшинд байна, [2;3] инфляци одоогийнхоос хурдан өснө.

Зураг 1.2: Ирэх 12 сарын хугацаанд үнийн түвшин хэрхэн өөрчлөгдөх вэ?




### 1.1 Хүлээлтийн ерөнхий хандлага

Чиглэлийн индекс нь иргэдийн инфляцийн хүлээлтийн хандлагыг харуулах бөгөөд хүлээлтийн судалгааг авч эхэлснээс хойшхи хугацааны туршид чиглэлийн индекс дунджаар 1.88 нэгж коэффициент буюу “инфляци одоогийнхтой адил түвшинд байна” гэсэн мужид байна.

**Зураг 1.1-ээс** харахад 2013 оны 1-р сарын байдлаар иргэдийн инфляцийн хүлээлтийн чиглэлийн индекс 1.97 нэгж коэффициент буюу “инфляци одоогийнхтой адил түвшинд байна” гэж хариулжээ. Өмнөх улирлын судалгааны дүнтэй харьцуулахад чиглэлийн индекс бага зэрэг өсөх хандлагатай гарсан байна. Ингэж өсөх хандлагатай гарсан шалтгаан нь 2013 он гараад бензин болон гол нэрийн бараа бүтээгдэхүүний үнэ нэмэгдсэнтэй холбоотой байх талтай.

Төрөөс мөнгөний бодлогын талаар баримтлах үндсэн чиглэлд хэрэглээний үнийн индексээр хэмжигдэх инфляцийг 2013 оны эцэст 8%-аас хэтрүүлэхгүй байхаар дурдсан бөгөөд иргэд 12 сарын дараа инфляцийн түвшинг бага зэрэг өснө гэсэн хүлээлттэй байна. Хүлээлтийн чанарын хариулт (**Зураг 1.2**) – аас харвал иргэдийн 68% нь ирэх 12 сард үнийн түвшин ерөнхийдөө өснө гэж үзсэн бөгөөд үүнээс 36% нь *үнийн түвшин хурдацтайгаар өснө* гэж хариулжээ. Энэ нь өмнөх судалгааны дүнгээс 7% буурсан байна.


Зураг 1.3: Жилийн инфляцийн хүлээлт



## 1.2 Инфляцийн хүлээлтийн тоон утга

Иргэдийн инфляцийн хүлээлтийг тооцохдоо одоогийн инфляцийн түвшинг суурь болгон ашигласан<sup>2</sup>. **Зураг 1.3**-аас харахад иргэд жилийн дараа инфляци одоогийн түвшнээсээ бага зэрэг өсөх буюу 17.2% гэж таамагласан байна. 2012 оны 1 дүгээр сарын инфляцийн хүлээлтийн судалгаагаар иргэд жилийн дараа инфляцийн түвшинг 13.3% байна гэж үзсэн нь 2013 оны 1 дугаар сарын инфляцийн таамаглалаас 0.9 хувийн зөрүүтэй байна. Иргэдийн хүлээлт өндөр гарсан шалтгаан нь түүвэр судалгааны чанарын хариултыг тоон утга болгож өөрчилсөн судалгааны аргачлалтай холбоотой.

Зураг 1.4: Хүлээлтийн түвшин, тоон хариулт (ирэх 12 сарын хугацаанд)



## 1.3 Инфляцийн хүлээлтийн тоон хариулт

Иргэдийн 12 сарын дараах хүлээлтийн түвшинг тодорхой тоон завсраас асуух замаар тооцоолол хийлээ. **Зураг 1.4**-өөс харахад 2013 оны 1 дүгээр сарын судалгаагаар иргэдийн 30% нь инфляцийг IV улирлын эцэст 13-15% байна гэж үзсэн бөгөөд тоон хариултуудын дундаж утга 11.7% байна. Харин өнгөрсөн 2012 оны 9 дүгээр сарын судалгаагаар иргэдийн 27% нь инфляцийг жилийн дараа 7-9% байна гэж үзэж, тоон хариултын дундаж утга нь 10.6% байсан байна.

Зураг 1.5: Иргэдийн инфляцийн хүлээлтийн харьцуулалт



## 1.4 Хүлээлтийн харьцуулалт

Иргэдийн улирлын хүлээлтийн чанарын асуултыг тоон утганд шилжүүлэн харьцуулан **Зураг 1.5**-аас харвал 2013 оны I улирлын эцэст иргэдийн инфляцийн хүлээлт тоон болон чанарын хариултын дунджаар 15.8%, II улирлын эцэст хүлээлтийн индекс 14.4% байна. Харин IV улирлын эцэст хүлээлтийн түвшинг харвал 14.4% болохоор байна. Иргэдээс авсан тоон утгыг харвал 2013 оны IV улирлын эцэст инфляци 11.7% болно гэж хариулжээ. Иргэдийн хүлээлт өндөр байгаа шалтгаан нь он гаргаад бензин болон өргөн хэрэглээний гол бараа бүтээгдэхүүний үнэ нэмэгдсэнтэй холбоотой.

<sup>2</sup>2012 оны 12-р сарын байдлаар инфляцийн түвшин 14.2% байсан.

Зураг 1.6: Таны бодлоор ирэх 12 сарын хугацаанд банкны зээлийн хүү хэрхэн өөрчлөгдөх вэ?




Зураг 1.7: Зээлийн хүүний хүлээлтийн индекс болон зээлийн хүү



Санамж: Чиглэлийн индекс нь [ -1;1 ] завсарт утгаа авна. [0;1] өснө, [0] хэвэндээ байна, [0;-1] буурна.

Зураг 1.8: Таны бодлоор ирэх 12 сард төгрөгийн ханш хэрхэн өөрчлөгдөх вэ?



Зураг 1.9: Төгрөгийн ханш болон төгрөгийн ханшийн чиглэлийн индекс



Санамж: Чиглэлийн индекс нь [ -1;1 ] завсарт утгаа авна. [0;1] ханш суларна, [0] хэвэндээ байна, [0;-1] чангарна.

## 1.5 Бусад асуултуудын хариулт

Судалгаанд оролцогчдын 37.0% нь ирэх 12 сарын хугацаанд зээлийн хүү хэвэндээ байна гэж үзсэн нь 2012 оны 12 дугаар сарын судалгааны дүнгээс 1.8 нэгж коэффициентоор өссөн дүнтэй байна. **Зураг 1.6**-аас харахад судалгаанд оролцогчдын 29% нь зээлийн хүү өснө гэж хариулсан нь өмнөх судалгааны үр дүнтэй харьцуулахад 3 хувиар өсч, хүү буурна гэсэн хариулт бага зэрэг буурсан дүнтэй гарсан байна.


**Зураг 1.7**-оос харахад 2012 оны IV улиралд арилжааны банкуудын зээлийн жигнэсэн дундаж хүү өмнөх улирлаас 1.4 хувиар өссөн бөгөөд үүнийг дагаад иргэдийн хүлээлтийн индекс 2013 оны 1 сарын судалгаагаар 0.21 нэгж буюу өмнөх судалгааны чиглэлийн индексээс 0.10 нэгжээр нэмэгдсэн байна.

Судалгаанд оролцсон иргэдийн 21% нь ирэх нэг жилд төгрөгийн ханш чангарна гэж үзсэн нь 2012 оны 9 дүгээр сарын судалгааны дүнтэй харьцуулахад 5 хувиар буурсан дүнтэй байна. Харин эсрэгээрээ төгрөгийн ханш суларна гэж үзсэн иргэдийн хувь 45% байгаа бөгөөд 9 дүгээр сарын судалгааны дүнгээс (**Зураг 1.8**-оос харна уу) 3 хувиар өссөн байна.

Иргэдийн төгрөгийн ханшийн хүлээлтийн чиглэлийн индексийг харвал энэ удаагийн судалгааны дүнгээр ханш суларна гэсэн хүлээлттэй гарсан байна (**Зураг 1.9**). 2012 оны I улиралд нэг доллар дунджаар 1,318 төгрөгтэй тэнцэж байсан бол II улиралд дунджаар 1,342 төгрөг болж өссөн нь 2012 оны I-II улирлын хооронд төгрөгийн ханш суларна гэсэн хүлээлт огцом өсөхөд нөлөө үзүүлсэн байх талтай. Харин энэ удаагийн судалгаагаар төгрөгийн ханш суларна гэж хүлээлттэй байгаа шалтгаан нь 2012 оны III дугаар улиралд нэг доллар дунджаар 1,375 төгрөгтэй тэнцэж байсан бол IV дүгээр улиралд 1,395 төгрөг болж өссөнтэй холбоотой.



**Зураг 1.10: Таны бодлоор ирэх 12 сард хадгаламжид мөнгө хийхэд тохиромжтой үе мөн үү?**




**Зураг 1.11: Хадгаламжийн жигнэсэн дундаж хүү болон хадгаламжийн хүүний чиглэлийн индекс**




Санамж: Чиглэлийн индекс нь [-1;1] завсарт утгаа авна. [0;1] өснө, [0] хэвэндээ байна, [0;-1] буурна.

**Зураг 1.12: Танай өрхийн санхүүгийн байдал ирэх 12 сарын хугацаанд хэрхэн өөрчлөгдөх вэ?**



**Зураг 1.13: Өрхийн санхүүгийн байдлын талаарх хүлээлтийн чиглэлийн индекс**



Санамж: Чиглэлийн индекс нь [-1;1] завсарт утгаа авна. [0;1] өрхийн санхүүгийн байдал сайжирна, [0] хэвэндээ байна, [0;-1] муудна.

**Зураг 1.10-аас** харахад судалгаанд оролцогчдын 32% нь ирэх 12 сарын хугацаанд хадгаламжид мөнгөө байршуулахгүй гэж үзэж байна. Харин ирэх 12 сарын хугацаанд хадгаламжид мөнгө хийхэд тохиромжтой гэж хариулсан иргэдийн хувь 2012 оны 9 дүгээр сарын судалгааны дүнгээс 1 хувиар өсч 21%-д хүрчээ.

**Зураг 1.11-д** банкуудын хадгаламжийн жигнэсэн дундаж хүү болон хадгаламжийн хүүний талаарх иргэдийн хүлээлтийн индексийг харуулсан болно. 2012 оны IV улирлын байдлаар банкуудын хадгаламжийн жигнэсэн дундаж хүү өмнөх улирлаас 0.5 хувиар өссөн байна. Үүнийг дагаад иргэдийн хүлээлтийн индекс өмнөх судалгааны дүнтэй харьцуулахад өсөх хандлагатай болсон хэдий ч хадгаламжийн хүү буурна гэсэн бүсэд байна.

Ирэх 12 сарын хугацаанд иргэдийн өрхийн санхүүгийн байдал сайжирна (**Зураг 1.12**) гэж судалгаанд оролцогчдын 31% хариулсан нь өмнөх улирлын судалгааны дүнгээс 5 хувиар өссөн байна. Харин өрхийн санхүүгийн байдал хэвэндээ байна, муудна гэсэн хариултуудын хувь өмнөх судалгаанаас 0.7 хувиар буурч 52%-д хүрсэн ба үүнээс өрхийн санхүүгийн байдал хэвэндээ байна гэсэн хариултын хувь 38%-тай гарчээ.


Өрхийн санхүүгийн байдал ирэх 12 сарын хугацаанд 2012 оны 9 дүгээр сарын судалгааны дүнтэй харьцуулахад 5 хувиар өссөн дүнтэй байгаа бөгөөд иргэд өрхийн санхүүгийн байдал сайжирна гэсэн хүлээлттэй байгааг **Зураг 1.13-оос** харах боломжтой. 2012 оны I-III улирлын хооронд инфляци дунджаар 15.8 хувьтай байсан нь өрхийн санхүүгийн байдлын чиглэлийн индекс буурахад нөлөө үзүүлсэн байна. Харин IV улиралд өрхийн санхүүгийн байдал сайжирна гэсэн хүлээлттэй гарахад инфляцийн түвшин буурч 14.2 хувьтай гарсан нь гол нөлөө үзүүлсэн байх талтай.

Зураг 1.14: Өрхийн санхүүгийн байдал сайжрах шалтгаан



Өрхийн санхүүгийн байдал сайжирна гэж судалгаанд оролцсон иргэдийн 31% нь хариулсан бөгөөд тэдгээрийн 65% ирэх 12 сард цалин нэмэгдэж, өрхийн гишүүн ажлын байртай болно гэж үзсэн байна. Мөн 15% нь бизнесийн орлого нэмэгдэнэ гэж хариулсан (Зураг 1.14-аас харна уу) байна.

Зураг 1.15: Өрхийн санхүүгийн байдал муудах шалтгаан



Зураг 1.15-аас харахад өрхийн санхүүгийн байдал муудна гэж иргэдийн 14% нь хариулсан бөгөөд тэдгээрийн 53% нь ирэх 12 сарын хугацаанд үнэ өссөнөөс шалтгаалан өрхийн санхүүгийн байдал муудна гэж хариулсан үндэслэл нь он гараад бензиний болон гол нэрийн бараа бүтээгдэхүүний үнэ нэмэгдсэнтэй холбоотой байх магадлалтай.

Харин 20% нь өрхийн гишүүн ажилгүй болно, төрөөс тэтгэмж тэтгэлэг авахгүй гэж хариулсан бол, мөн 9% нь татварын ачаалал ихэснэ гэж үзжээ.

## ДҮГНЭЛТ

Инфляцийн хүлээлтийн ерөнхий хандлага буюу чиглэлийн индекс өмнөх судалгааны дүнгээс бага зэрэг өсч “инфляци одоогийн түвшиндээ байна” гэсэн мужид байна. Иргэдийн хүлээлт ингэж өмнөх судалгааны дүнгээс бага зэрэг өсөх хандлагатай гарахад он гараад бензин болон өргөн хэрэглээний гол бараа бүтээгдэхүүний үнэ нэмэгдсэнтэй холбоотой байх талтай.

Арилжааны банкуудын зээлийн жигнэсэн дундаж хүү 2012 оны IV улиралд өмнөх улирлаасаа бага зэрэг өссөн нь ирэх 12 сарын хугацаанд иргэд зээлийн хүү өснө гэсэн хүлээлттэй гарахад нөлөө үзүүлсэн байх талтай. Иргэдийн төгрөгийн ханшийн хүлээлтийн чиглэлийн индексийг харвал 2013 оны эцэст ханш суларна гэсэн хүлээлт бага зэрэг өсчээ. Ирэх 12 сарын хугацаанд өрхийн санхүүгийн байдал сайжирна гэж үзсэн иргэдийн ихэнх нь цалин нэмэгдэнэ, өрхийн гишүүд ажлын байртай болно гэсэн хүлээлттэй байна. Үүнд аж ахуй нэгжүүд үйл ажиллагаа өргөжүүлж шинээр ажлын байрыг нэмэгдүүлэх төлөвтэй байгаа нь нөлөөлсөн байх талтай.



## 2. АЖ АХУЙН НЭГЖҮҮДИЙН ИНФЛЯЦИЙН ХҮЛЭЭЛТИЙН ТҮҮВЭР СУДАЛГААНЫ ДҮН

Аж ахуйн нэгжүүдийн дунд явуулсан инфляцийн хүлээлтийн түүвэр судалгаанд Улаанбаатар хотод үйл ажиллагаа эрхэлж буй нийт 400 аж ахуйн нэгжийг хамрууллаа. Судалгааны үр дүнгээр аж ахуйн нэгжүүд 2013 оны I улирлын эцэст инфляцийн түвшинг **11.5%**, 2013 оны II улирлын эцэст **8.9%**, харин 2013 оны IV улирлын эцэст **9.3%**-д хүрнэ гэсэн хүлээлттэй байна.

| Хүснэгт 2.1 Аж ахуйн нэгж /өмчлөлөөр/ |            |               |
|---------------------------------------|------------|---------------|
| Аж ахуйн нэгжийн хэлбэр               | тоо        | хувь          |
| Нөхөрлөл                              | 20         | 5.0%          |
| Хоршоо                                | 16         | 4.0%          |
| Хувьцаат компани                      | 8          | 2.0%          |
| Хязгаарлагдмал хариуцлагатай компани  | 355        | 88.8%         |
| Төрийн өмчит үйлдвэрийн газар         | 1          | 0.3%          |
| <b>НИЙТ ДҮН</b>                       | <b>400</b> | <b>100.0%</b> |

| Хүснэгт 2.2 ААН-ийн үйлдвэрлэл, үйлчилгээ /салбараар/ |            |               |
|-------------------------------------------------------|------------|---------------|
| САЛБАРЫН БҮЛЭГ                                        | тоо        | хувь          |
| Хөдөө аж ахуй                                         | 14         | 3.5%          |
| Уул, уурхай олборлох                                  | 21         | 5.3%          |
| Боловсруулах үйлдвэр                                  | 6          | 1.5%          |
| Барилга                                               | 31         | 7.8%          |
| Бөөний болон жижиглэнгийн худалдаа                    | 125        | 31.3%         |
| Жижиг, дунд үйлдвэр                                   | 55         | 13.8%         |
| Үйлчилгээ                                             | 124        | 31.0%         |
| Бусад                                                 | 24         | 6.0%          |
| <b>НИЙТ ДҮН</b>                                       | <b>400</b> | <b>100.0%</b> |

| Хүснэгт 2.3 ААН-ийн салбарын бүлэг /ажилчдын тоогоор/ |                        |           |           |          |            |
|-------------------------------------------------------|------------------------|-----------|-----------|----------|------------|
| Салбарын бүлэг                                        | Ажилчдын тоо /бүлгээр/ |           |           |          | Бүгд       |
|                                                       | < 10                   | 11-50     | 51-100    | 101 <    |            |
| Хөдөө аж ахуй                                         | 11                     | 2         | 1         | 0        | 14         |
| Уул уурхай, олборлох                                  | 12                     | 6         | 1         | 2        | 21         |
| Боловсруулах үйлдвэр                                  | 3                      | 1         | 2         | 0        | 6          |
| Барилга                                               | 13                     | 16        | 0         | 2        | 31         |
| Б/Ж-ийн худалдаа                                      | 110                    | 13        | 2         | 0        | 125        |
| Жижиг, дунд үйлдвэрлэл                                | 40                     | 11        | 2         | 2        | 55         |
| Үйлчилгээ                                             | 94                     | 25        | 2         | 3        | 124        |
| Бусад                                                 | 16                     | 7         | 1         | 0        | 24         |
| <b>НИЙТ ДҮН</b>                                       | <b>299</b>             | <b>81</b> | <b>11</b> | <b>9</b> | <b>400</b> |

### 2.1. ТҮҮВЭР СУДАЛГААНД ОРОЛЦОГЧИД

Судалгаанд хамрагдсан нийт 400 аж ахуй нэгжүүдийг өмчлөлийн хэлбэрээр авч үзвэл дийлэнх буюу 355 (88.8%) нь хязгаарлагдмал хариуцлагатай компани, 20 (5.0%) нь нөхөрлөл, 16 (4.0%) нь хоршоо байсан бол үлдсэн 9 (2.3%) нь хувьцаат компани болон төрийн өмчит үйлдвэрийн газар байна. /Хүснэгт 2.1/


Аж ахуйн нэгжүүдийг үйл ажиллагаа эрхэлж буй эдийн засгийн салбараар ангилбал үйлчилгээ эрхэлдэг аж ахуйн нэгж 124 (31.0%), бөөний болон жижиглэнгийн худалдаа эрхэлдэг 125 (31.3%), жижиг дунд үйлдвэрлэл эрхэлж буй 55 (13.8%), барилгын салбарт үйл ажиллагаа эрхэлдэг 31 (7.8%), уул уурхай, олборлох 21 (5.3%), хөдөө аж ахуйн салбарын 14 (3.5%) аж ахуйн нэгж байсан бол боловсруулах үйлдвэр болон бусад салбарт үйл ажиллагаа эрхэлж буй 30 (7.5%) аж ахуйн нэгж тус тус хамрагдсан байна. /Хүснэгт 2.2/

Түүвэр судалгаанд хамрагдсан ААН-үүдийг эдийн засгийн салбар болон ажилчдын бүлгээр авч үзвэл 10 хүртэлх ажилчидтай ААН-ийн тоо 299 (74.7%), үүний 110 (27.5%) нь бөөний болон жижиглэнгийн худалдаа, 94 (23.5%) нь үйлчилгээ, 40 (10.0%) нь жижиг, дунд үйлдвэрлэл эрхэлдэг байна. 11-50 хүртэлх ажилчидтай 81 (20.2%) ААН хамрагдсан бөгөөд үүний 25 (6.2%) нь үйлчилгээ, 16 (4.0%) нь барилга, 13 (3.2%) нь худалдаа, 11 (2.7%) жижиг дунд үйлдвэрлэл эрхэлдэг байна. 51-100 хүртэлх ажилчидтай 11 (2.7%), 101-ээс дээш ажилчидтай ААН-ийн тоо 9 буюу нийт судалгаанд оролцогчдын 2.2%-ийг эзэлж байна. /Хүснэгт 2.3/


## 2.2. ҮНИЙН ЕРӨНХИЙ ТҮВШИННИЙ ХҮЛЭЭЛТ

Аж ахуйн нэгжүүдийн дунд 2013 оны 1-р сард инфляцийн хүлээлтийн санал асуулгыг явуулахдаа чанарын болон тоон хариултыг авах 2 аргачлалын хүрээнд хүлээлтийг тооцсон.

Зураг 2.1 Үнийн ерөнхий түвшин ирэх 12 сард




Зураг 2.2а ААН-ийн инфляцийн хүлээлтийн чиглэлийн индекс



Санамж: Чиглэлийн индекс нь (-1;3) завсарт утгаа авна. Нэмэх чиглэл рүү хүлээлтийн хандлага өссөн, хасах чиглэл рүү инфляцийн хүлээлтийн хандлага буурсан байгааг илтгэнэ.

Зураг 2.2b ААН-ийн инфляцийн хүлээлт




### ҮНИЙН ЕРӨНХИЙ ТҮВШИН /чанарын хариулт/

Инфляцийн хүлээлтийн түүвэр судалгааны үндсэн асуултад судалгаанд оролцсон нийт аж ахуйн нэгжүүдийн 48.6% нь үнийн түвшин ерөнхийдөө өснө гэсэн нь өмнөх судалгааны дүнгээс 14.1 нэгж хувиар буурсан байна. Үнэ хурдацтай өснө гэж хариулсан ААН-үүд өмнөх судалгааны дүнгээс 5.7 нэгж хувиар буурч 14.0%-тай байна. Харин 12 сарын дараа буюу 2013 оны IV улиралын эцэст үнэ өснө гэхдээ хурдац өөрчлөгдөхгүй гэж 26.8%, үнэ өснө гэхдээ өсөлтийн хурдац буурна гэж 7.8% нь хариулсан бол 22.3% нь үнэ өөрчлөгдөхгүй, 5.0% нь үнэ буурна гэж хариулжээ. /Зураг 2.1/

ААН-ийн инфляцийн хүлээлтийн чиглэлийн индекс 2012 оны 7-р сард 1.60 нэгж байсан бол 2013 оны 1-р сард буурч 1.24 болсон нь аж ахуйн нэгжүүд 12 сарын дараа инфляци буурна гэсэн ерөнхий хүлээлттэй байна. Бодлого баригчдын зүгээс авч хэрэгжүүлж буй өргөн хэрэглээний гол бараа, бүтээгдэхүүний үнийг тогтворжуулах дэд хөтөлбөрүүдийн хүрээнд хэрэгжүүлж буй үйл ажиллагаатай холбоотойгоор инфляцийн хүлээлт буурчээ /Зураг 2.2а/.

Чанарын хариултыг Карлсон-Паркины аргачлалаар тоон үзүүлэлт рүү шилжүүлэн тооцоход аж ахуйн нэгжийн хүлээгдэж буй инфляцийн түвшин 2013 оны I улирлын эцэст **11.5%**, 2013 оны II улирлын эцэст **8.9%** байна гэсэн бол 2013 оны IV улирлын эцэст инфляци **9.3%**-тай байна гэж хүлээгдэж байна. /Зураг 2.2b/. Өмнөх судалгааны /2012-7 сар/ дүнгээр ААН-үүдийн инфляцийн хүлээлт 2012 оны III улирлын эцэст 15.2%, IV улирлын эцэст 14.2%-тай байсан бол инфляцийн түвшин харгалзан 15.1%, 14.2-тай гарчээ.


Зураг 2.3 ААН-ийн 12 сарын дараах үнийн өсөлтийн түвшин /харьцангуй давтамж/



## ҮНИЙН ЕРӨНХИЙ ТҮВШИН /тоон хариулт/

Түүвэр судалгаанд оролцсон нийт аж ахуйн нэгжүүдийн 12 сарын дараах инфляцийн хүлээлтийн түвшинг тоон интервалиар тодорхойлох замаар санал асуулгыг авч үр дүнг нэгтгэхэд 12 сарын дараах хүлээгдэж буй инфляцийн түвшин **10.7%**-тай байна /Зураг 2.3/.

Зураг 2.4 ААН-ийн бүтээгдэхүүн, үйлчилгээний өнгөрсөн 6 сар дахь эрэлт




## 2.3. Бусад хариулт

## БҮТЭЭГДЭХҮҮН, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЭРЭЛТ


Судалгаанд оролцсон нийт аж ахуйн нэгжүүдийн бүтээгдэхүүн болон үйлчилгээний өнгөрсөн 6 сарын хугацаан дахь эрэлтийн хувьд санал асуулгад оролцогчдын 29.0% нь өссөн гэж хариулсан бөгөөд өмнөх судалгааны дүнтэй харьцуулахад 13.6 нэгж хувиар буурсан байна. Харин эрэлт өөрчлөгдөөгүй гэж 48.3% нь хариулсан бол 22.8% нь эрэлт буурсан гэж хариулжээ. Өнгөрсөн онд инфляцийн түвшин харьцангуй өндөр байсан нь иргэдийн худалдан авах чадварыг бууруулж улмаар эрэлтийг бууруулсан байх талтай байна. /Зураг 2.4/

Зураг 2.5 ААН-ийн бүтээгдэхүүн, үйлчилгээний ирэх 6 сарын эрэлт




Судалгаанд оролцогч ААН-ийн 43.3% нь ирэх 6 сарын хугацаанд бүтээгдэхүүн, үйлчилгээний эрэлт өснө гэж хариулсан байна. Эдийн засгийн өсөлттэй холбоотойгоор аж ахуйн нэгжүүд өөрсдийн бүтээгдэхүүн, үйлчилгээний эрэлт өснө гэсэн хүлээлттэй байх магадлалтай. Бүтээгдэхүүн, үйлчилгээний эрэлт ирэх 6 сард өөрчлөгдөхгүй гэж 28.0% нь, эрэлт буурна гэж 7.3% нь хариулжээ. Харин ирэх 6 сарын эрэлтийг мэдэхгүй гэж хариулсан нь 21.5% буюу харьцангуй өндөр хувьтай байна. /Зураг 2.5/.

Зураг 2.6 ААН-үүдийн ажлын байр ирэх 6 сард



Зураг 2.7 ААН-үүдийн цалин ирэх 6 сард



Зураг 2.8 ААН-үүдийн ирэх 6 сар дахь цалингийн дундаж өсөлт



Хүснэгт 2.4 ААН-ийн ажлын байр, цалингийн өсөлт

| Ирэх сард ажилчдын тоо хэрхэн өөрчлөгдөх вэ? | Ирэх 6 Сард цалингаа өсгөх үү? |       |          |
|----------------------------------------------|--------------------------------|-------|----------|
|                                              | Тийм                           | Үгүй  | Нийт дүн |
| Нэмэгдэнэ                                    | 20.0%                          | 13.5% | 33.5%    |
| Өөрчлөгдөхгүй                                | 12.8%                          | 50.5% | 63.3%    |
| Буурна                                       | 0.3%                           | 3.0%  | 3.3%     |
| Нийт дүн                                     | 33.0%                          | 67.0% | 100.0%   |

## АЖИЛ ЭРХЛЭЛТ, ЦАЛИН


Судалгаанд хамрагдсан ААН-үүдийн 33.5% нь ирэх 6 сарын хугацаанд ажлын байраа нэмэгдүүлнэ гэсэн бөгөөд өмнөх судалгааны дүнгээс 1.9%-иар буурсан байна. Харин 63.3% нь өөрчлөгдөхгүй гэж хариулсан бөгөөд өмнөх судалгааны дүнгээс 2.2%-иар өссөн бол үлдсэн 3.2% нь бууруулна гэж хариулжээ /Зураг 2.6/. Ирэх 6 сард ААН-үүдийн хувьд үйл ажиллагаагаа өргөжүүлэхийн зэрэгцээ ажлын байраа нэмэгдүүлэх хандлагатай байна.

Ирэх 6 сард судалгаанд хамрагдсан нийт ААН-үүдийн 33% цалингаа нэмнэ гэсэн бол үлдсэн 67% нь өөрчлөхгүй гэж хариулжээ. Энэ нь өмнөх судалгааны дүнтэй харьцуулбал цалингаа нэмэгдүүлэх ААН-үүдийн тоо 8 нэгж хувиар буурсан байна /Зураг 2.7/.

ААН-үүд ирэх 6 сард цалингийн түвшингээ дунджаар 14.2%-иар нэмэгдүүлэхээр байгаа нь өмнөх судалгааны дүнгээс 0.7 нэгж хувиар буурсан үзүүлэлт юм. ААН-үүдийн инфляцийн хүлээлттэй уялдан цалингийн түвшний хүлээгдэж буй өсөлт буурах хандлагатай байна /Зураг 2.8/.

Түүнчлэн судалгаанд оролцсон ААН-ийн 20.0% нь ирэх 6 сард ажлын байрны тоогоо нэмэгдүүлэхийн зэрэгцээ цалингаа өсгөхөөр байна. Харин цалингийн хэмжээндээ өөрчлөлт оруулахгүйгээр ажилчдынхаа тоог нэмэгдүүлнэ гэж хариулсан ААН-үүдийн тоо нийт судалгаанд оролцогчдын 13.5%-г эзэлж байна /Хүснэгт 2.4/


Зураг 2.9 ААН-ийн санхүүжилт авах эх үүсвэр



Хүснэгт 2.6 ААН-үүдийн санхүүжилт авах эх үүсвэр үйл ажиллагаа эрхэлдэг салбараар

| Салбарын бүтэг         | Санхүүжилтийн хэлбэр |                            |                |                     |                     |                     | Нийт дүн |
|------------------------|----------------------|----------------------------|----------------|---------------------|---------------------|---------------------|----------|
|                        | Банкны санхүүжилтээр | Компанийн өөрийн хөрөнгөөр | Хувьцаа гаргах | Гадаад эх үүсвэрээр | СБ-ийн эх үүсвэрээр | Тэтгэлэг тусламжаар |          |
| Хөдөө аж ахуй          | 1.0%                 | 1.0%                       | 0.0%           | 1.0%                | 0.5%                | 0.0%                | 3.5%     |
| Уул уурхай, олборлох   | 0.0%                 | 2.0%                       | 0.0%           | 0.0%                | 0.0%                | 0.5%                | 2.5%     |
| Боловсруулах үйлдвэр   | 0.5%                 | 0.5%                       | 0.0%           | 0.0%                | 0.0%                | 0.0%                | 1.0%     |
| Барилга                | 2.5%                 | 6.0%                       | 0.0%           | 0.5%                | 0.0%                | 0.5%                | 9.5%     |
| Б/Ж-ийн худалдаа       | 14.9%                | 11.4%                      | 0.5%           | 0.5%                | 0.5%                | 1.5%                | 29.4%    |
| Жижиг, дунд үйлдвэрлэл | 6.5%                 | 5.5%                       | 0.0%           | 0.5%                | 1.5%                | 0.0%                | 13.9%    |
| Үйлчилгээ              | 14.9%                | 11.9%                      | 0.5%           | 3.0%                | 2.0%                | 2.5%                | 34.8%    |
| Бусад                  | 2.0%                 | 3.0%                       | 0.0%           | 0.0%                | 0.0%                | 0.5%                | 5.5%     |
| Нийт дүн               | 42.3%                | 41.3%                      | 1.0%           | 5.5%                | 4.5%                | 5.5%                | 100.0%   |

Зураг 2.10 ААН-ийн ирэх 6 сарын зээлийн хэрэгцээ




## САНХҮҮЖИЛТ БОЛОН ЗЭЭЛ

Компаниа өргөжүүлэх төлөвлөгөөтэй байгаа ААН-үүдийн хувьд 42.3% нь банкны санхүүжилтээр, 41.3% нь компанийн өөрийн хөрөнгөөр санхүүжинэ гэсэн бол үлдсэн 16.4% нь гадаад эх үүсвэр, хувьцаа гаргах, бусад санхүүгийн байгууллагын эх үүсвэр, тэтгэлэг тусламж зэрэг бусад эх үүсвэрээр санхүүжихээр байна. Өмнөх судалгааны дүнтэй харьцуулахад банкны санхүүжилт буюу банкны зээл нь ААН-ийн санхүүжилтийн гол эх үүсвэр хэвээр байна /Зураг 2.9/

Ирэх 6 сарын хугацаанд үйл ажиллагаагаа өргөжүүлэхээр төлөвлөж буй ААН-үүдийг эдийн засгийн салбараар авч үзвэл үйлчилгээний салбарт үйл ажиллагаа явуулж буй компаниуд буюу судалгаанд оролцогчдын 14.9% нь банкны санхүүжилтээр санхүүжих сонирхолтой байна. Харин банкнаас санхүүжилт авах сонирхолтой ААН-ийн 14.6%-ийг бөөний болон жижиглэнгийн худалдаа эрхлэгчид, 6.5%-ийг жижиг, дунд үйлдвэрлэл, 2.5%-ийг барилга, 2.5%-ийг боловсруулах болон бусад салбарууд тус тус эзэлж байна. Эдийн засгийн салбаруудын хувьд банкны зээл нь санхүүжилтийн гол эх үүсвэр болж байгаа бол бусад төрлийн санхүүжилтийн эх үүсвэрээр санхүүжих магадлал харьцангуй бага байна /Хүснэгт 2.5/.

Нийт судалгаанд оролцсон аж ахуйн нэгжүүдийн хувьд ирэх 6 сард зээлийн хэрэгцээ нэмэгдэнэ гэж 44.3% нь хариулсан бол өөрчлөгдөхгүй гэж 48.8%, харин үлдсэн 5.8% нь буурна гэжээ. ААН-үүдийн хувьд үйл ажиллагаа нь улирлын шинж чанараас хамаарч эхний хагас жилд банкны зээлийн санхүүжилт илүү хэрэгцээтэй байдаг нь харагдаж байна /Зураг 2.10/.


Зураг 2.11а ААН-ийн ханшийн түвшний хүлээлт



## ХАНШИЙН ХҮЛЭЭЛТ

Судалгаанд хамрагдсан аж ахуйн нэгжүүдийн 62.9% нь валютын ханш 2013 оны II улирлаас эхлэн харьцангуй тогтвортой байна гэж хариулсан. Харин 18.6% нь 2013 оны IV улирлын эцэст ханш бага зэрэг чангарна, 30.8% нь ханш бага зэрэг суларна гэсэн бол 50.6% нь тогтвортой байна гэжээ /Зураг 2.11а/.

Зураг 2.11б ААН-ийн 12 сарын дараах ханшийн түвшин



Өмнөх судалгааны дүнтэй харьцуулахад валютын ханш чангарна гэсэн хариулт 8.5 нэгж хувиар, ханш суларна гэсэн хариулт 16.9 нэгж хувиар тус тус буурсан бол ханш тогтвортой байна гэсэн хариулт 25.4 нэгж хувиар өссөн нь ААН-үүд 12 сарын дараа ханш харьцангуй тогтвортой байна гэсэн хүлээлттэй байна /Зураг 2.11б/.

## ДҮГНЭЛТ


Санал асуулгын дүнгээр аж ахуйн нэгжүүдийн хувьд инфляцийн хүлээлт өмнөх оны инфляцитай харьцуулахад буурах хандлагатай байна. Инфляцийн хүлээлт буурах хандлагатай байгаа нь бодлого баригчдын зүгээс авч хэрэгжүүлж буй өргөн хэрэглээний гол бараа, бүтээгдэхүүний үнийг тогтворжуулах дэд хөтөлбөрүүдийн үйл ажиллагаатай холбоотой. Үйлчилгээ, бөөний болон жижиглэнгийн худалдааны салбарт үйл ажиллагаагаа явуулж буй ААН-үүдийн бүтээгдэхүүн, үйлчилгээний үнийн өсөлт инфляцид голлон нөлөө үзүүлдэг байх талтай байна. Эдийн засгийн өсөлттэй уялдан бүтээгдэхүүн, үйлчилгээний эрэлт нэмэгдэх хандлагатай байна. Үйл ажиллагаагаа өргөжүүлэхийн зэрэгцээ ажлын байрыг нэмэгдүүлэх аж ахуйн нэгжийн тоо бага зэрэг өсчээ. Үйл ажиллагаагаа өргөжүүлэхийн тулд ААН-үүд банкны зээлээр санхүүжих сонирхолтой байна. Харин ААН-үүдийн хувьд валютын ханш 2013 онд харьцангуй тогтвортой байна гэсэн хүлээлттэй байна.



### 3. ШИНЖЭЭЧДИЙН ИНФЛЯЦИЙН ХҮЛЭЭЛТИЙН ТҮҮВЭР СУДАЛГААНЫ ДҮН

Шинжээчдийн инфляцийн хүлээлтийн судалгаанд арилжааны банк, хөгжлийн банк, их сургууль болон бусад байгууллагад судалгаа, шинжилгээ хийдэг нийт 12 шинжээч оролцов. Уг санал асуулгад эдийн засгийн гол үзүүлэлтүүд (инфляци, нийт мөнгөний өсөлт, төгрөгийн ханш, ДНБ-ий өсөлт, цалин)-ийг багтаасан бөгөөд хариултыг шууд тоон үзүүлэлтээр авч, шинжээчдийн таамгуудын жигнэсэн дунджаар хүлээлтийг тооцоолов. Судалгааны дүнгээс харахад шинжээчид жилийн инфляци 2013 оны I улирлын эцэст 14.0%, 2013 оны II улирлын эцэст 12.7%, оны эцэст 11.8% болохоор тус тус таамаглаж байна.

**Зураг 3.1 Инфляци**




Эх сурвалж: Монголбанк

Тайлбар: Сүүдэрлэсэн талбай шинжээчдийн таамгийн харуулах бөгөөд хамгийн их, бага болон дундаж утгуудыг зураасаар дүрслэв.

#### 3.1. ИНФЛЯЦИ

Шинжээчдийн таамгаар жилийн инфляци 2013 оны 1-р улиралд 14.0%, 2, 3-р улиралд 12.7%, 12.9%, оны эцэст 11.8% болохоор тус тус хүлээгдэж байна. Өмнөх судалгаатай харьцуулахад 2013 оны 1, 2-р улирлын инфляцийн хүлээлт 0.5-1.3 орчим нэгж хувиар буурсан байна. Шинжээчдийн таамгаас харахад хамгийн өндөр хүлээлттэй нь 1-р улиралд инфляци 19.5%, хамгийн бага хүлээлттэй нь оны эцэст 7.5% болохоор таамаглажээ /Зураг 3.1/.

**Зураг 3.2 Нийт мөнгөний өсөлт /M2/**




Эх сурвалж: Монголбанк

Тайлбар: Сүүдэрлэсэн талбай шинжээчдийн таамгийг харуулах бөгөөд хамгийн их, бага болон дундаж утгуудыг зураасаар дүрслэв.

#### 3.2. НИЙТ МӨНГӨНИЙ ӨСӨЛТ /M2/

Мөнгөний нийлүүлэлт 2013 онд 17.8-21.3%-ийн хооронд өсөлттэй байхаар таамаглаж байна. 2013 оны 1-р улиралд M2 мөнгөний өсөлт саарч, 2-р улирлаас эхлэн өсөхөөр байна. Шинжээчдийн таамаглалыг өмнөх судалгаатай харьцуулахад дунджаар 10.0 орчим нэгж хувиар буурсан байна. Шинжээчдээс хамгийн өндөр хүлээлттэй нь 3-р улиралд M2 мөнгөний жилийн өсөлт 32.0%, хамгийн бага хүлээлттэй нь 1-р улиралд 6% байхаар тус тус таамаглажээ /Зураг 3.2/.




**Зураг 3.3 Төгрөг/долларын ханш**

Эх сурвалж: Монголбанк

Тайлбар: Сүүдэрлэсэн талбай шинжээчдийн таамгийг харуулах бөгөөд хамгийн их, бага болон дундаж утгуудыг зураасаар дүрслэв.

**3.3. ТӨГРӨГИЙН АМ.ДОЛЛАРТАЙ ХАРЬЦАХ ХАНШ**

Шинжээчид төгрөгийн ам.доллартай харьцах нэрлэсэн ханш 2013 оны эхний хагас хүртэл чангарч 1382 төгрөгт хүрэх бөгөөд сүүлийн хагаст бага зэрэг сулрахаар төсөөлж байна. Өмнөх судалгааны дүнтэй харьцуулахад 2013 оны 1, 2-р улирлын ханшийн хүлээлт 5.8-5.6%-иар суларсан байна. Шинжээчдийн таамгаас харахад хамгийн өндөр хүлээлттэй нь оны эцэст долларын ханш 1447.0 төгрөг, хамгийн бага хүлээлттэй нь 1310.0 төгрөг байхаар тус тус тооцоолжээ /Зураг 3.3/.


**Зураг 3.4 Төгрөг/юаны ханш**

Эх сурвалж: Монголбанк

Тайлбар: Сүүдэрлэсэн талбай шинжээчдийн таамгийг харуулах бөгөөд хамгийн их, бага болон дундаж утгуудыг зураасаар дүрслэв.

**3.4. ТӨГРӨГИЙН ЮАНЬТАЙ ХАРЬЦАХ ХАНШ**

Төгрөгийн юаньтай харьцах нэрлэсэн ханш 2013 онд харьцангуй тогтвортой 222.5-225 төгрөг байхаар хүлээгдэж байна. Өмнөх судалгаатай харьцуулахад 2013 оны 1, 2-р улирлын юаны ханшийн хүлээлт 5-7%-иар суларсан байна. Шинжээчдийн таамгаас хамгийн өндөр хүлээлттэй нь оны эцэст юанийн ханш 245.8 төгрөг, хамгийн бага хүлээлттэй нь 207.0 төгрөг байхаар тус тус таамаглажээ /Зураг 3.4/.

**Зураг 3.5 ДНБ-ий жилийн өсөлт**


Эх сурвалж: Монголбанк

Тайлбар: Сүүдэрлэсэн талбай шинжээчдийн таамгийг харуулах бөгөөд хамгийн их, бага болон дундаж утгуудыг зураасаар дүрслэв.

**3.5. ДНБ-ИЙ ЖИЛИЙН ӨСӨЛТ**

ДНБ-ий өсөлт 2013 онд тогтвортой нэмэгдэх бөгөөд 12.9-15%-ийн өсөлттэй байхаар таамаглаж байна. Энэ нь өмнөх судалгаатай харьцуулахад 1, 2-р улирлын таамаглал харгалзан 3.6, 4.9 нэгж хувиар буурчээ. Шинжээчдийн таамгаас харахад хамгийн өндөр хүлээлттэй нь 2013 оны 2-р улиралд ДНБ-ий өсөлт 17.9%, хамгийн бага хүлээлттэй оны эцэст 8.7% болохоор тус тус таамаглаж байна /Зураг 3.5/.

Зураг 3.6 Сарын дундаж нэрлэсэн цалин



Эх сурвалж: Монголбанк

Тайлбар: Сүүдэрлэсэн талбай шинжээчдийн таамгийг харуулах бөгөөд хамгийн их, бага болон дундаж утгуудыг зураасаар дүрслэв.

## 3.6. САРЫН ДУНДАЖ НЭРЛЭСЭН ЦАЛИН

Шинжээчдийн таамгаар сарын дундаж нэрлэсэн тогтмол өсөх бөгөөд 2013 оны эцэст 670.0 мянган төгрөгт хүрч, одоогийн түвшнээс 18.5%-иар өснө гэж тооцоолж байна. Өмнөх судалгаатай харьцуулахад шинжээчдийн цалингийн хүлээлт бараг хэвээрээ байна. Шинжээчдийн таамгаас хамгийн өндөр хүлээлттэй нь 2013 онд дундаж нэрлэсэн цалин 736.3 мянган төгрөг, хамгийн бага хүлээлттэй 590.9 мянган төгрөг байхаар тус тус таамаглажээ /Зураг 3.6/.

## ДҮГНЭЛТ

Шинжээчдийн таамгаас харахад инфляци 2013 оны 1-р улиралд 14.0%-иас оны эцэст 11.8% хүртэл буурах хүлээлттэй байна. Мөнгөний нийлүүлэлтийн өсөлт 2012 оны 1-р улиралд бага зэрэг саарч, 2-р улирлаас эхлэн нэмэгдэх хандлагатай байна. Бодит ДНБ 2013 оны турш тогтмол өсөх бөгөөд оны эцэст 15%-ийн өсөлттэй байхаар таамаглажээ. Төгрөгийн ам.доллартай харьцах нэрлэсэн ханш 2013 оны эхний хагас хүртэл чангарч, сүүлийн хагаст бага зэрэг сулрах төсөөлөлттэй байна. Харин юаньтай харьцах нэрлэсэн ханш харьцангуй тогтвортой байхаар хүлээлттэй байна. Сарын дундаж цалин тогтвортой өсөхөөр таамаглаж байна.